- Монгол улсын Засгийн газрын 2024.01.03 өдрийн 02 тогтоол, Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай 2024.01.03 өдрөөс мөрдөж ажиллах
- Монгол улсын Сангийн сайдын 2024.03.27 тушаал, Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай А/52 тогтоолыг 2024.04.01 өдрөөс мөрдөж ажиллах
- Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.
- Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Дархан-Уул аймаг Дархан сумын 10 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 10 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75,933.57 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 133,129.5 | 162,464.2 | 29,334.7 |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 84,404.01 | 75,754.90 | 8,649.11 |
| Үндсэн хөрөнгө | 1,197,999.48 | 1,253,247.48 | 55,248.00 |
| **Нийт хөрөнгө** | **1,415,532.99** | **1,491,466.56** | **(75,933.57)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,415,532.99 | 1,491,466.56 | 75,933.57 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,415,532.99** | **1,491,466.56** | **(75,933.57)** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 162,464.2 мянган төгрөг болж өмнөх оноос 29,334.7 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын цалингийн сан, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хүүхдийн хоол хүнсний зардал, бараа үйлчилгээний бусад зардалаас төгрөгийг хэмнэж Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын

байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75,754.90 мянган төгрөг болж 8,649.11 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд хүнсний үлдэгдэл өндөр байсныг бууруулж ажилласан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,253,247.48 мянган төгрөг болж 55,248.00 мянган төгрөгөөр өссөн нь 115,795.00 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандив болон өөрийн хөрөнгөөр авсан нь өсөхөд нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,491,466.56 мянган төгрөг болж 75,933.57 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данснууд байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 993,277.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 74,160,5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,0678,438.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн зардлыг 22,962.5 мянган, орон нутгаас санхүүжих зардлыг 10,160.5 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвийн санхүүжилтийг 970,315.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 64,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2024 оны төсвийн төслийг Засгийн газрын тогтоолоор цалин хөлс нэмэгдсэн, гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгосон, хүүхэд хамгааллын зардал, хүүхдийн хоолны зардал, нөхөн хангалтын зардал батлагдсан зэргээс шалтгаалсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 113,581.3 мянган төгрөгөөр *нэмэгдүүлж* тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 хөтөлбөрийн 81834, 81835. 81807 арга хэмжээг санхүүжүүлэхээр тодотгосон.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1.051,943.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 64,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 2,368.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,022,478,12 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 29,465,4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас хэмнэлт үүссэнтэй холбоотой байна. Орон нутгийн төсвөөс 2,368.46 мянган төгрөгийн үүссэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 81834 | 1,033,170.3 | 886,605.35 | (146,565.0) | 85.8 |
| 2 | 81835 | 35,745.4 | 35,745.4 | - | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 81807 | 101,722.0 | 91,447.57 | (10,274.43) | 89.90 |
| 4 | 81605 | 5,179.4 | 2,207.0 | (2,972.1) | 42.61 |
| 5 | 80233 | 1,450.1 | 1,450.1 | - | 100.0 |
| 6 | 81823 | 3.401.4 | 750.00 | (2,651.4) | 22.05 |
| 7 | 80111 | 79,301.60 | 61,631.53 | (17,670.07) | 96.29 |
| 8 | 81816 | 4,403.5 | 4,403.5 | | 100.0 |
| | Дүн | 1,260,052.4 | 1,086,608.95 | (175,811.93) | 86.04 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

1. Ахмадын сангийн судалгаа

Тус цэцэрлэгээс өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад байхгүй тул ахмадын сан үүсгээгүй.

2. ХАА судалгаа- 2024 онд 97,654.0 мянган төгрөгийн хоол хүнсний материал худалдан авахаар харьцуулалтын аргаар тендер 5 удаа зарласан боловч оролцогчгүй амжилтгүй болсон. Хоол хүнсний худалдан авалтыг үнийн харьцуулалтын аргаар шууд гэрээ байгуулан ажилласан.

3. Судалгаа 210801 - Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/ зардал байхгүй.

4.Судалгаа 210901 - Багшийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, багшийн сургалтын зардал, ариутгал цэвэрлэгээний бодис худалдан авах, дотоод албан томилолт,бага үнэтэй түргэн элэгдэх зардал, бичиг хэрэг,интернэтийн зардал, аудит, төлбөр хураамжийн зардлууд багтсан ба нийт 24,622.12 мянган төгрөг зарцуулсан.

5.Орон тооны судалгаа - 2024 онд батлагдсан орон тоо 41. Тайлант онд тоонд өөрчлөлт гараагүй.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

### *3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл*

2024 онд 97,654.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны 5 төсөл боловсруулж төлөвлөсөн. Хоол хүнсний 97,654.0 мянган төгрөгийн тендер харьцуулалтын аргаар 5 удаа зарласан боловч нэг ч оролцогчгүй, амжилтгүй болсон.Хоол хүнсний материал нийлүүлэх компаниудаас үнийн санал авч харьцуулалтын аргаар шууд худалдан авах хийх гэрээг Өег гурил ХХК, Цэцэн марал ХХК, Арцат алтайн уулс ХХК, иргэн Д. Даважав, иргэн Н. Даваахүү нартай хийсэн. Мэдээлэл технологийн зардал 3,187,16 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардал 10,509.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 17,054.2 мянган төгрөг, эрүүл мэндийн зардлаас 2,972.4 мянган төгрөг, хоол хүнсний зардлаас 91,447.57 мянган төгрөгийг шууд худалдан авалтаар тус тус зарцуулсан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 34.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 10 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 10 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 814,903.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16,298.1 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй хэмнэлттэй ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Дархан-Уул аймгийн 10 дугаар цэцэрлэг нь 2024 онд мэдээлбэл зохих 171 мэдээллийн хуульд заасан хугацаанд 168 бүрэн байршуулсан байгаа ба 3 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан байгууллагын батлагдсан төсөв мэдээллийг 3 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулж байх зөвлөмж өгөх

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 10 дугаар цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн цалингийн зардлын данстай холбоотой асуудлаао 1 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад 100.0 хувь хэрэгжсэн байна

*Хүснэгт 4* зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Зөвлөмж | 1 | 3,842.0 | 1 | 3,842.0 | 100.0 |
| **Нийт дүн** | **1** | **3,842.0** | **1** | **3,842.0** | **100** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Боловсролын ерөнхий газрын даргын -ын 2024 оны 01 сарын 12 өдөр баталсан 809,017.0 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 12 сарын 28 өдөр 238,844.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл

86,5 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,741.6 төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,656.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,084.9 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд:

- Хангамжийн материалд авах ёстой 1,656.8 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн хэрэгслийн материалын тусгай зориулалттай материал дээр авсан тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 3.4 дэх хэсэг, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайлан бүртгэж залруулсан.

Аудитаар нийт 1,084.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,084.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

*5.3.1.1.Илрүүлэлт:*

Байгуулагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж, ажилтнуудад 9,916,5 мянган төгрөг олгохдоо 991.5 мянган төгрөгийн НДШ суутгаагүй, 93.4 мянган төгрөг ХХОАТ илүү төлсөн нийт 1,084.9 мянган төгрөгийн зөрчил нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3.ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал; Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна: 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; заалттай нийцэхгүй байна

*5.3.1.2. Өгсөн зөвлөмж:*

Хууль тогтоомжийн заалтуудыг хэрэгжүүлэн цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад [illegible] бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зардал хооронд гүйлгэн бүртгэсэн | 1 | 1,656.8 | | | 1 | 1,656.8 | 1 | 1,656.8 | | | | |
| Дүн | 1 | 1,656.8 | | | 1 | 1,656.8 | 1 | 1,656.8 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зардлын данстай холбоотой асуудал | 1 | 1,084.9 | - | - | - | - | 1 | 1,084.9 | - | - | - | - |
| Дүн | 1 | 1,084.9 | | | | | 1 | 1,084.9 | | | | |

Тайлангийн 4.4.1, 4.4.2 дахь хэсэгт дурдсан шилэн дансны тухай хууль болон, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[4]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж |

[3] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

[4] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ... төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зардал хооронд гүйлгэн бүртгэсэн | 1 | 1,656.8 | | | 1 | 1,656.8 | 1 | 1,656.8 | | | | |
| Дүн | 1 | 1,656.8 | | | 1 | 1,656.8 | 1 | 1,656.8 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зардлын данстай холбоотой асуудал | 1 | 1,084.9 | - | - | - | - | 1 | 1,084.9 | - | - | - | - |
| Дүн | 1 | 1,084.9 | | | | | 1 | 1,084.9 | | | | |

Тайлангийн 4.4.1, 4.4.2 дахь хэсэгт дурдсан шилэн дансны тухай хууль болон, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[4]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж |

[3] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

[4] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх [illegible] төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 шийдвэр мэдээлээгүй байна. | 1 | | - | - | - | - | 1 | |
| Дүн | 1 | | - | - | - | - | 1 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Дүн | 1 | - | - | - | - | - | - | |
| Нийт дүн | 2 | | - | - | - | - | 2 | |